



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 08 дугаар сарын 19
№ 31 (1229)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

582. Төрийн албаны тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2391

583. Нийтийн албанд нийтийн болон
хувийн ашиг сонирхлыг зохицуулах,
ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан
сэргийлэх тухай хуульд нэмэлт
оруулах тухай 2398

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

584. Элчин сайдыг эгүүлэн татах,
тохоон томилох тухай Дугаар 49 2399

585. Элчин сайдыг эгүүлэн татах,
тохоон томилох тухай Дугаар 50 2399

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

586. Журам батлах тухай Дугаар 133 2400

587. Журам батлах тухай Дугаар 150 2411

588. Дүрэм батлах тухай Дугаар 153 2416

589. Жагсаалт батлах тухай Дугаар 154 2424

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг:

“19.2.Төрийн тусгай албан тушаалыг энэ хуулийн 18.1-д заасан төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалтыг Засгийн газрын саналыг үндэслэн төрийн албаны төв байгууллага батална.”

2/20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг:

“20.2.Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалыг энэ хуулийн 18.1-д заасан төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалтыг Засгийн газрын саналыг үндэслэн төрийн албаны төв байгууллага батална.”

3/23 дугаар зүйлийн 23.3, 23.4 дэх хэсэг:

“23.3.Энэ хуулийн 11.1-д заасан албан тушаалд ажилласан хугацааг төрийн захиргааны албан тушаалын зохих ангилалд ажилласан хугацаанд дүйцүүлэн тооцож болно.

23.4.Энэ хуулийн 23.3-т заасан хугацааг төрийн захиргааны албан тушаалын ангилалд хамаарах албан тушаалд ажилласан хугацаанд дүйцүүлэн тооцох журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.”

4/44 дүгээр зүйлийн 44.5, 44.6 дахь хэсэг:

“44.5.Томилох эрх бүхий этгээд төрийн жинхэнэ албан хаагчид өөрт нь мэдэгдэн тухайн байгууллагын нэгж хооронд шилжүүлэн ажиллуулж болно.

44.6.Энэ хуулийн 44.2-т заасан төрийн жинхэнэ албан хаагчийг сэлгэн ажиллуулж байгаа байгууллага түүнийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр дахин өөр төрийн байгууллагад үргэлжлүүлэн сэлгэн ажиллуулж болохгүй.”

5/49 дүгээр зүйлийн 49.3 дахь хэсэг:

“49.3.Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөний аливаа үйл ажиллагаанд дайчлах, чиг үүрэгт нь үл хамаарах ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.”

2 дугаар зүйл.Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.12 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албаны шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж болно.” гэсэн 1 дэх өгүүлбэр, 44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсэгт “Төрийн жинхэнэ албан хаагчийг сэлгэн ажиллуулах хугацаа дуусахаас өмнө урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь буцаан ажиллуулах нөхцөл байдал үүссэн тохиолдолд анх илгээсэн төрийн байгууллагын саналыг авч, харилцан тохиролцсоны дагуу шийдвэрлэнэ.” гэсэн 2 дахь өгүүлбэр тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Төрийн албаны тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг:

“33.3.Ерөнхий шалгалтыг төрийн жинхэнэ алба хаах хүсэлтэй, энэ хуулийн 22.1-д заасан шаардлагыг хангасан иргэн, төрийн үйлчилгээний болон улс төрийн албан хаагчаас, тусгай шалгалтыг энэ хуулийн 18.1-д заасан төрийн захиргааны албан тушаалын ангилал хооронд шилжих тохиолдолд болон энэ хуулийн 27.1.3, 33.8-д заасан нөөцөд байгаа иргэдээс тус тус авна.”

2/44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсэг:

“44.2.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагчийг өөрийнх нь зөвшөөрснөөр төрийн байгууллага хооронд тэдгээрийн удирдлага харилцан тохиролцсоны дагуу, эсхүл тухайн байгууллагын нэгж хооронд ажлын тодорхой чиглэлээр хоёр жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно. Хэрэв төрийн албан хаагч өөрөө буюу түүнийг сэлгэн ажиллуулж байгаа байгууллага хүсвэл анх илгээсэн төрийн байгууллага болон өөрийнх нь зөвшөөрснөөр сэлгэн ажиллуулах хугацааг нэг жил хүртэл хугацаагаар сунгаж болно.”

3/66 дугаар зүйлийн 66.1.7 дахь заалт:

“66.1.7.чиг үүргийн шинжилгээ хийхэд төрийн байгууллагад мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх;”

4 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1 дэх заалтын “16-аас” гэснийг “12-оос” гэж, “8-аас” гэснийг “6-аас” гэж,



мөн зүйлийн 23.2.2 дахь заалтын “12-оос” гэснийг “8-аас” гэж, мөн зүйлийн 23.2.3 дахь заалтын “8-аас” гэснийг “6-аас” гэж, “4-өөс” гэснийг “3-аас” гэж, мөн зүйлийн 23.3, 23.4, 23.5, 23.6 дахь хэсгийн дугаарыг “23.5, 23.6, 23.7, 23.8” гэж, мөн зүйлийн 23.4, 23.5 дахь хэсгийн “23.3-т” гэснийг “23.5-д” гэж, 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.1.2 дахь заалтын “, эсхүл” гэснийг “болон” гэж, 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн “Төрийн” гэснийг “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн” гэж, мөн зүйлийн 33.7 дахь хэсгийн “жилд” гэснийг “улиралд” гэж, мөн зүйлийн 33.4, 33.9 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.11 дэх заалтын “шалгалт /тухайн албан тушаалын/-ыг” гэснийг “шалгалтыг” гэж, 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсгийн “44.2-т” гэснийг “44.2, 44.5-д” гэж, мөн зүйлийн 44.5, 44.6 дахь хэсгийн дугаарыг “44.7, 44.8” гэж, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсгийн “Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас” гэснийг “Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон,” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.2 дахь заалт, 33.10, 33.12 дахь хэсгийн “/тухайн албан тушаалын/” гэснийг, 66 дугаар зүйлийн 66.1.8 дахь заалтын “, улсын болон орон нутгийн төсвийн удирдлагын зардлын төслийг боловсруулах, хянаж батлахад зохих журмын дагуу санал гаргах” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4 дэх заалтыг, 64 дүгээр зүйлийн 64.2.3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 23.11 дэх хэсэг нэмсүгэй:

“23.11.Авлигатай тэмцэх газар энэ хуулийн 23.6 дахь хэсэгт зааснаас бусад асуудлаар дүгнэлт, мэдэгдэл гаргахыг хориглоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Хуульчийн үндсэн зар тусламж

Хуульчийн үндсэн зар тусламж 2007 оны 09 сарын 10-ны өдөр баталсан хуулийн 10-д заагдсан зэрэгт

Хуульчийн үндсэн зар тусламж 2007 оны 09 сарын 10-ны өдөр баталсан хуулийн 10-д заагдсан зэрэгт

Хуульчийн үндсэн зар тусламж 2007 оны 09 сарын 10-ны өдөр баталсан хуулийн 10-д заагдсан зэрэгт

Хуульчийн үндсэн зар тусламж 2007 оны 09 сарын 10-ны өдөр баталсан хуулийн 10-д заагдсан зэрэгт

Хуульчийн үндсэн зар тусламж 2007 оны 09 сарын 10-ны өдөр баталсан хуулийн 10-д заагдсан зэрэгт

Хуульчийн үндсэн зар тусламж 2007 оны 09 сарын 10-ны өдөр баталсан хуулийн 10-д заагдсан зэрэгт



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 04 дүгээр
сарын 06-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Монтенегро Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ганхуурайн Баттунгалагийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Монтенегро Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Мижиддоржийн Цэнгэгийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 04 дүгээр
сарын 06-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бутаны Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Гончигийн Ганболдыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бутаны Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дамбажавын Ганболдыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 3 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 133

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Кино урлагийг дэмжих тухай хуулийн 17.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Кино бүтээх зардлын буцаан олголтын хүсэлт гаргах, төслийг хянах, бүртгэх, гэрээ байгуулах, үнэлэх, тайлагнах, зардлын тодорхой хувийг буцаан олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Соёлын сайд Ч.Номинд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

СОЁЛЫН САЙД

Ч.НОМИН

Засгийн газрын 2022 оны 133
дугаар тогтоолын хавсралт

КИНО БҮТЭЭХ ЗАРДЛЫН БУЦААН ОЛГОЛТЫН ХҮСЭЛТ ГАРГАХ, ТӨСЛИЙГ ХЯНАХ, БҮРТГЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ҮНЭЛЭХ, ТАЙЛАГНАХ, ЗАРДЛЫН ТОДОРХОЙ ХУВИЙГ БУЦААН ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын хуулийн этгээд дангаараа болон Монгол Улсын хуулийн этгээдтэй хамтран олон улсад түгээх зорилгоор кино бүтээх тохиолдолд зардлын тодорхой хувийг буцаан олгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Кино бүтээх зардлын буцаан олголт (цаашид “буцаан олголт” гэх)-ын үйл ажиллагааны эрх зүйн үндэс нь Төсвийн тухай хууль, Кино урлагийг дэмжих тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмаас бүрдэнэ.

1.3.Буцаан олголтын үйл ажиллагаанд хууль дээдлэх, улс төрийн нөлөөллөөс ангид, нээлттэй, ил тод, тэгш шударгаар өрсөлдөх боломжтой, хялбаршуулсан зохицуулалт бүхий, хэрэгжихүйц, тодорхой байх зарчмыг баримтална.

1.4. Кино урлагийг дэмжих тухай хуулийн 15.2, 15.3-т заасны дагуу буцаан олголтын зардлыг өмнөх оны төсөвт тусгагдсанаас бууруулахгүй байх бөгөөд тухайн төсвийн жилд ашиглагдаагүй төсвийн үлдэгдлийг дараагийн төсвийн жилд үргэлжлүүлэн зарцуулна.

1.5. Кино бүтээх зардлын тодорхой хувийг буцаан олгох үйл ажиллагааг Кино урлагийн зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) зохион байгуулна.

1.6. Энэ журмын 1.5-д заасан үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах бөгөөд цахим үйлчилгээний технологи хэрэгслийг нэвтрүүлэх, ашиглах нөхцөл, холбогдох заавар, аргачлалыг Зөвлөл тогтооно.

1.7. Зөвлөл буцаан олголтын хүсэлт, төсөл хүлээн авах, бүртгэх, гэрчилгээ олгох, мэдүүлэг гаргахтай холбоотой маягт, загвар болон бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг баталж, цахим хуудсанд байршуулна.

1.8. Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авалт хийх зардлын тодорхой хувийг буцаан авах нөхцөлтэйгөөр хүсэлт гаргах этгээд (цаашид “хүсэлт гаргах этгээд” гэх) нь Монгол Улсын хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн гадаадын хуулийн этгээд, эсхүл гадаадын хуулийн этгээдтэй Кино урлагийг дэмжих тухай хуулийн 4.1.3-т заасны дагуу хамтарсан кино бүтээхээр, эсхүл кино зураг авалт хийхэд нь хамтран ажиллахаар гэрээ байгуулсан Монгол Улсын хуулийн этгээд байна.

1.9. Кино урлагийг дэмжих тухай хуулийн 4.1.3-т заасны дагуу хамтарсан кино бүтээх тохиолдолд кино бүтээх нийт санхүүжилтийн 20-оос илүүгүй хувийг Монгол Улсын кино продюсер, эрх эзэмшигч санхүүжүүлэхээр холбогдох гэрээндээ тусгасан байна.

1.10. Зөвлөлөөс кино зураг авалт хийх зардлын тодорхой хувийг буцаан олгохтой холбоотой төсөв, шалгуур, холбогдох мэдээллийг монгол болон олон улсын өргөн хэрэглэгддэг гадаад хэлээр бэлтгэн олон улсад сурталчлах, таниулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хоёр. Кино бүтээх зардлын тодорхой хувийг буцаан олгоход тавигдах нөхцөл

2.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авалт хийхэд зарцуулсан зардлын тодорхой хувийг буцаан олгоход дараах нөхцөл тавигдана:

2.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авалт хийхэд Кино урлагийг дэмжих тухай хуулийн 15.4-т заасан 500 000 америк доллар

буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгийг энэ журмын 4.2-т заасан гэрээ байгуулсан өдрөөс хойш Кино урлагийг дэмжих тухай хуулийн 15.4, 16.1 дэх хэсэг болон энэ журамд заасан шаардлага хангасан зардалд зарцуулсан байх;

2.1.2.Монгол Улсын Кино урлагийг дэмжих сангаас санхүүжилт аваагүй байх.

2.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт киноны эвлүүлэг, дуу, дүрсний найруулга хийсэн зардлын 30 хувийг буцаан олгоход энэ журмын 2.1-д заасан нөхцөлөөс гадна Кино урлагийг дэмжих тухай хуулийн 17.2-т заасан шаардлагыг хангасан байх нөхцөл тавигдана.

2.3.Бүтээсэн кино нь энэ журмын 2 дугаар хавсралтад заасан соёлын шалгуур хангасан этгээдэд кино зураг авалтын зардлын 10 хувийг нэмж буцаан олгоход энэ журмын 2.1-д заасан нөхцөлөөс гадна Кино урлагийг дэмжих тухай хуулийн 17.3-т заасан шаардлагыг хангасан байх нөхцөл тавигдана. Энэ журмын 2 дугаар хавсралтад заасан үзүүлэлтээс 21 болон түүнээс дээш оноо авсан тохиолдолд Соёлын шалгуурыг хангасанд тооцно.

2.4.Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авалт хийсэн зардлыг буцаан олгохдоо эхний ээлжид гадаад улсын уран бүтээлч, зураг авалтын багийн гишүүдийн Монгол Улсад ажилласан хоногийн цалин хөлсний зардлын хувийг тооцон гаргана. Гадаад улсын уран бүтээлч, зураг авалтын багийн гишүүдийн Монгол Улсад ажилласан хоногийн цалин хөлсний 5 хувийг шууд буцаан олгоно.

2.5.Уран бүтээлийн болон зураг авалтын багийн цалин хөлс нь Кино урлагийг дэмжих тухай хуулийн 15.4-т заасан шаардлага хангасан нийт зардлын 40 хувиас хэтрэхгүй байна.

2.6.Гадаад улсын уран бүтээлийн болон зураг авалтын багийн Монгол Улсад ажилласан хоногийн цалин хөлс нь нийт уран бүтээлийн болон зураг авалтын багийн цалин хөлсний 50 хувиас хэтрэхгүй байна.

2.7.Монгол Улсад байхгүй нь нотлогдсон мэргэжлийн техник, тоног төхөөрөмжийг гадаад улсаас түрээслэн ашигласны зардал нь Кино урлагийг дэмжих тухай хуулийн 15.4-т заасан нийт зардлын 10 хувиас хэтрэхгүй байна.

Гурав.Буцаан олголтын хүсэлт гаргах

3.1.Хүсэлт гаргах этгээд энэ журамд заасан нөхцөл, шаардлагыг хангасан хүсэлтээ Зөвлөлөөс баталсан маягтын дагуу гаргах бөгөөд хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргасан байна:



3.1.1.Монгол Улсад хийгдэх зураг авалтын нэгдсэн болон нарийвчилсан төсөв;

3.1.2.кино төслийн болон кино зохиолын хураангуй;

3.1.3.санхүүгийн төлөвлөгөө, хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтын хувь;

3.1.4.хуулийн этгээдийн гэрчилгээ;

3.1.5.кино түгээлтийн мэдээлэл;

3.1.6.Монгол Улсын нутаг дэвсгэрт хийх кино зураг авалтын хуваарь;

3.1.7.кино зураг авалтад оролцох гадаад улсын уран бүтээлийн болон зураг авалтын багийн дэлгэрэнгүй жагсаалт, тэдгээрийн Монгол Улсад ажилласан хоногийн цалин хөлсний тооцооны мэдээлэл;

3.1.8.эвлүүлэг, дуу, дүрсний найруулга хийх хуваарь, хэрэв Монгол Улсад хийх бол тухайн эвлүүлэг, дуу, дүрсний найруулгын зардлын мэдээлэл, Монгол Улсын уран бүтээлч, ажилтны мэдээлэл;

3.1.9.хэрэв Кино урлагийг дэмжих тухай хуулийн 17.2, 17.3-т заасан буцаан олголт авах бол энэ тухай хүсэлт;

3.1.10.шаардлагатай бусад мэдээлэл.

3.2.Хүсэлт гаргах этгээд буцаан олголтын хүсэлт гаргахдаа кино бүтээх нийт зардлын 60-аас доошгүй хувийг бүрдүүлсэн байна.

3.3.Хүсэлт гаргах этгээдийн гаргасан хүсэлт, хэрэгжүүлэх төсөл нь Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчөөгүй, монголын түүхийг илт гуйвуулах болон дайн, түрэмгийлэл, садар самуун, хүчирхийллийг сурталчлах агуулгагүй байна.

3.4.Зөвлөлийн ажлын алба хүсэлт, баримт бичгийн бүрдүүлбэрийг хянан үзэж, шаардлага хангасан бол Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ. Бүрдүүлбэрийн шаардлага хангаагүй баримт бичгийг хүсэлт гаргасан этгээдэд буцаах буюу хугацаа зааж холбогдох баримт бичиг нэмж гаргуулж авна. Заасан хугацаанд холбогдох баримт бичгийг нэмж гаргаж өгөөгүй бол ирүүлсэн баримт бичгийг хүсэлт гаргасан этгээдэд буцаана.

3.5.Зөвлөл буцаан олголтыг хүсэлтийг улирал бүр хэлэлцэнэ.

Дөрөв.Төслийг бүртгэх, гэрчилгээ олгох

4.1.Зөвлөл хүсэлт, төслийг хэлэлцэж, хууль, журамд заасан шаардлага хангасан тохиолдолд бүртгэн гэрчилгээ олгоно. Гэрчилгээг төслийн хугацаанаас хамаарч хоёроос дөрөв хүртэлх жилийн хугацаатай олгоно.

4.2.Зөвлөл нь гэрчилгээ авсан этгээдтэй кино зураг авалт хийх зардлын тодорхой хувийг буцаан олгох гэрээг гэрчилгээ олгосноос хойш 3 сарын дотор байгуулна. Гэрээнд гэрээг цуцлах нөхцөлийг тодорхой тусгана.

4.3.Гэрчилгээ авсан этгээд энэ журмын 4.2-т заасан хугацаанд гэрээ байгуулаагүй бол Зөвлөл гэрчилгээг хүчингүй болгоно.

4.4.Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал, урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсөл хэрэгжих боломжгүй болсон тохиолдолд гэрчилгээ авсан этгээд нь Зөвлөлд нэн даруй мэдэгдэх бөгөөд ийнхүү мэдэгдсэнээр гэрчилгээ хүчингүй болж, гэрээ цуцлагдсанд тооцно.

4.5.Зөвлөлөөс Кино урлагийг дэмжих тухай хуулийн 18.5-д заасан дээд хязгаарт багтаан гэрчилгээний хугацааг сунгаж болно. Гэрчилгээний хугацааг сунгасан шийдвэрийг үндэслэн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна.

Тав.Шаардлага хангасан зардал, зардлын зарцуулалт

5.1.Энэ журмын 4.2-т заасан гэрээ байгуулсан этгээд гэрээнд заасан хугацаанд багтаан кино зураг авалтыг хийж, мөн журмын 2.1.1-д заасан хөрөнгийг гэрээ байгуулсан өдрөөс хойш гэрчилгээ, гэрээнд заасан дансаар дамжуулан зарцуулна. Уг данс нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хийх кино зураг авалтыг санхүүжүүлэх, ашиглах, буцаан олголтыг шилжүүлэх данс байна.

5.2.Зардлын тодорхой хувийг буцаан олгох гэрээ байгуулсан өдрөөс хойш Монгол Улсын нутаг дэвсгэрт зарцуулсан зардлыг буцаан олголтод тооцно.

5.3.Кино зураг авалт хийхэд Кино урлагийг дэмжих тухай хуулийн 15.4, 16.1 дэх хэсэгт заасан шаардлага хангасан зардалд энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан “Шаардлага хангасан зардлын дэлгэрэнгүй жагсаалт”-д заасан зардлыг тооцно.

5.4.Кино урлагийг дэмжих тухай хуулийн 16.2-т зааснаас гадна дараах зардлыг шаардлага хангасан зардалд тооцохгүй:

5.4.1.гэр ахуйн цахилгаан хэрэгсэл худалдан авах зардал;

5.4.2.зураг авалтын явцад ашиглах компьютер худалдан авахаас бусад албан тасалгааны тавилга, албан тасалгааны тоног төхөөрөмж худалдан авах зардал;

5.4.3.элэгдлийн зардал;

5.4.4.байгууллагын үйл ажиллагаанд ашиглахад хамаарах (оффисын) программ хангамжийг худалдан авах, хөгжүүлэх зардал.

5.5.Эвлүүлэг, дуу, дүрсний найруулгыг Монгол Улсын нутаг дэвсгэрт хийх зардлыг тооцохдоо энэ журмын 5.3-т заасныг харгалзан үзнэ.

Зургаа.Мэдүүлэг гаргах, үнэлгээ хийх

6.1.Гэрээ байгуулсан этгээд кино зураг авалтыг хийж, 500 000 америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгийг Монгол Улсад зарцуулсан бол эвлүүлэг, дуу, дүрсний найруулгыг хийх, энэ журмын 2 дугаар хавсралтад заасан соёлын шалгуур хангасан эсэхээс үл хамааран Кино урлагийг дэмжих тухай хуулийн 17.1-д заасан буцаан олголт авах мэдүүлгийг гаргаж болно.

6.2.Энэ журмын 6.1-д заасан мэдүүлэг гаргасан этгээд Кино урлагийг дэмжих тухай хуулийн 17.2-т заасан буцаан олголт авах мэдүүлгийг Монгол Улсад дуу, дүрсний найруулгыг хийж дууссаны дараа гаргана.

6.3.Энэ журмын 6.1-д заасан мэдүүлэг гаргасан этгээд бүтээсэн кино нь энэ журмын 2 дугаар хавсралтад заасан соёлын шалгуурыг хангасан гэж үзсэн тохиолдолд Кино урлагийг дэмжих тухай хуулийн 17.2-т заасан буцаан олголт авах мэдүүлгийг кино бүтээсний дараа гаргана.

6.4.Энэ журмын 6.1-6.3-т заасан мэдүүлгийг гэрчилгээнд заасан хугацаа дуусахаас 60-аас доошгүй хоногийн өмнө Зөвлөлд хандан гаргана.

6.5.Кино урлагийг дэмжих тухай хуулийн 17.5-д заасан монгол киноны эрх эзэмшигч дараах шалгуурыг хангасан тохиолдолд буцаан олголт авах мэдүүлэг гаргана:

6.5.1.кино бүтээхэд 500 000 америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгийг зарцуулсан;

6.5.2.сүүлийн 2 жилийн хугацаанд бүтээсэн кино нь Монгол Улсыг олон улсад эергээр сурталчлан таниулж, энэ журмын 2 дугаар хавсралтад заасан “Соёлын шалгуур”-ыг хангасан;

6.5.3.кино продюсерын нийгэмлэгүүдийн олон улсын холбооноос баталсан олон улсын кино наадамд амжилттай оролцсон.

6.6.Энэ журмын 6.5-д заасан мэдүүлгийг үнэлэхэд мөн журмын 6.7-6.18-д заасныг мөрдөнө.

6.7.Мэдүүлэг гаргагч мэдүүлэг гаргахын өмнө нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийн эх хувийг бүрдүүлж, аудит хийлгэн тайлангаа шалгуулсан байна. Аудит нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасан төлбөрийн баримтын зардлын дүнг тодорхойлсон байна.

6.8.Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авалт хийхдээ зарцуулсан шаардлага хангасан зардлын тайлан болон дараах баримт бичгийг Зөвлөлөөс баталсан мэдүүлэг гаргах маягтад хавсаргана:

6.8.1.аудитаар баталгаажуулсан хураангуй болон зардлын нарийвчилсан тайлан, аудитын дүгнэлт;

6.8.2.Монгол Улсад зарцуулсан зардалтай холбоотой баримт, нотолгоо, зардлыг тусгасан банкны дансны хуулга, бусад баримт;

6.8.3.нягтлан бодох бүртгэлийн цахим тайлан;

6.8.4.жүжигчид болон кино төслийн багийн бүрэн жагсаалт, гэрээ, түгээлтийн гэрээ;

6.8.5.үзвэр/театрын дэлгэцэд гаргахад тохиромжтой стандартад нийцүүлэн бэлдэж дууссан бол түүнийг нотлох Зөвлөлийн бэлгэдэл болон Монголын кино багийг баталгаажуулсан кино бүтээгчийн тамга бүхий киноны хуулбар (Blu-ray);

6.8.6.Зөвлөлөөс баталгаажуулан олгосон хүчинтэй буцаан олголтын гэрчилгээний эх хувь.

6.9.Эвлүүлэг, дуу, дүрсний найруулгыг Монгол Улсын нутаг дэвсгэрт хийсэн бол багийн бүрэлдэхүүний 50-аас доошгүй хувь нь Монгол Улсын уран бүтээлч, ажилтан оролцсон эсэхийг батлах хөдөлмөрийн гэрээ, төлбөрийн баримтын хуулбар, холбогдох татвар төлсөн баримт зэрэг нэмэлт баримт бичгийг ирүүлнэ.

6.10.Мэдүүлэг гаргагч нь мэдүүлэгтээ кино зураг авалт, эвлүүлэг, дуу, дүрсний найруулга хийхэд зарцуулсан зардлын баримтын эх хувьтай танилцах, зардлыг шалгах эрхийг олгохоо хүлээн зөвшөөрсөн байна.

6.11.Монгол Улсад зарцуулсан зардлын талаарх мэдээллийг татварын болон холбогдох байгууллагаас авах ажлыг Зөвлөл зохион байгуулна.

6.12.Зөвлөл зардлын баримтыг судалж, Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авалт хийхдээ зарцуулсан шаардлага хангасан зардлын тооцоо, тайланг баталгаажуулах эсэх болон эвлүүлэг, дуу, дүрсний найруулгыг Монгол Улсын нутаг дэвсгэрт хийхэд багийн бүрэлдэхүүний 50-аас доошгүй хувь нь Монгол Улсын уран бүтээлч, ажилтан оролцсон эсэх, энэ журмын 2 дугаар хавсралтад заасан соёлын шалгуурын дагуу оноо өгч, онооны шаардлага хангасан эсэх, Кино урлагийг дэмжих тухай хуулийн 19.5-д заасан буцаан олголтын хувь тооцох дүгнэлтийг тус тус гарган соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

6.13.Зөвлөл дараах тохиолдолд Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авалт хийхдээ зарцуулсан шаардлага хангасан зардлын тооцоо, тайланг баталгаажуулахгүй буцаана:

6.13.1.мэдүүлэг шаардлага хангаагүй;

6.13.2.Кино урлагийг дэмжих тухай хуулийн 19.7-д заасан нөхцөл үүссэн;

6.13.3.хуурамч баримт бичиг үйлдсэн нь тогтоогдсон.

6.14.Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ журмын 6.12-т заасан дүгнэлтийг үндэслэн зардлын тодорхой хувийг буцаан олгох шийдвэр гаргана.

6.15.Энэ журмын 6.14-т заасан шийдвэрийг үндэслэн Зөвлөл буцаан олголтыг гэрээнд заасан дансанд шилжүүлнэ.

6.16.Гэрээнд заасан бол Монгол Улсад кино зураг авалт хийсэн зардлын буцаан олголтын 70 хүртэл хувийг киноны эхний эвлүүлэг хийх үед, үлдсэн хувийг кино түгээсний дараа олгох байдлаар хуваан шилжүүлж болно.

6.17.Зөвлөлийн бүрэлдэхүүн өөрчлөгдсөн нь буцаан олголтын талаар олгосон гэрчилгээ, гэрээ, холбогдох баримтад өөрчлөлт оруулах, нэмэлт нөхцөл шаардах үндэслэл болохгүй.



6.18.Буцаан олголт авсан этгээд киноны төгсгөлийн киноны жүжигчид болон багийн гишүүдийн мэдээллийн хэсэгт (титр) Монголын Кино урлагийн зөвлөл гэсэн бичиг, түүнийг илэрхийлэх бэлгэдэл, мэдээллийг байршуулна.

Долоо.Хариуцлага

7.1.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

7.2.Энэ журмыг зөрчсөний улмаас учирсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

---оОо---

Журмын 1 дүгээр хавсралт

ШААРДЛАГА ХАНГАСАН ЗАРДЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ЖАГСААЛТ

1.Найруулагч, ерөнхий зураглаач, ерөнхий зураач, кино продюсер (гүйцэтгэх продюсер, продюсер, лайн продюсер), зургийн дарга, хөгжмийн зохиолч болон уран бүтээл, зураг авалтын багийн цалин хөлс, түүнтэй холбоотойгоор Монгол Улсад төлсөн холбогдох татвар;

2.Киноны хөгжим зохиох зардал, дотоодын хөгжимчид болон хөгжим, дуу, бүжгийн чуулга, хөгжмийн зохиолчийн зардал, түүнтэй холбоотойгоор Монгол Улсад төлсөн холбогдох татвар;

3.Энэ жагсаалтын 1-д зааснаас бусад зураглаачийн баг (зураглаач, туслах зураглаач, фокус тохируулагч гэх мэт), гэрэлтүүлгийн баг, дууны багийн цалин хөлс, түүнтэй холбоотойгоор Монгол Улсад төлсөн холбогдох татвар;

4.Зураачийн багийн туслах зураач, тайзны болон жижиг хэрэглэлийн зураач, тайз засалч, тайз чимэглээч, мужаан, цахилгаанчин, гагнуурчин, тайзны бусад ажилтны цалин хөлс, түүнтэй холбоотойгоор Монгол Улсад төлсөн холбогдох татвар болон тайз засалд шаардлагатай тоног төхөөрөмж, материал (барилгын материал, зургийн талбай бэлтгэх зардал, жижиг хэрэглэлийн түрээс, тайз барих хөлс, мужааны хэрэглэл, будаг, даавуу гэх мэт)-ын зардал;

5.Хувцас, нүүр хувиргах (хувцас худалдан авах, оёх, түрээслэх зардал, хувцасны дизайнер, хувцасны зураач ба эрхлэгч, нүүр хувиргагчийн

болон үс засалтын багийн ажлын хөлс, холбогдох бусад)-тай холбоотой зардал;

6.Монгол Улсын нутаг дэвсгэрт байхгүй мэргэжлийн болон тусгай эффектийн төхөөрөмжийг түрээслэн ашиглахтай холбоотой зардал;

7.Техникийн баг, зураг хяналтын баг, тэдгээртэй холбоотой засвар, үйлчилгээний зардал, компьютер графикч, мэдээллийн дата менежерийн цалин хөлс, холбогдох тоног төхөөрөмж болон харилцаа холбоо, гар утас, интернэтийн зардал;

8.Уран бүтээлчдийн хоёрдугаар баг буюу дотоодын орлон тоглогч ажиллуулах, үндэсний найрал, симфони найрал хөгжим, урлагийн байгууллагууд, бусад тайз, дэлгэцийн урлагийн байгууллагуудаас болон нэмэлтээр хүний хүч ажиллуулах зардал;

9.Нэмэлт ажилчид буюу бүжиг дэглээч, зэвсэг хариуцагч, цэргийн зөвлөх, хэл ярианы дасгалжуулагч, амьтан сургагч, жолооч, цэвэрлэгээний ажилтан, аюулгүй байдлын мэргэжилтэн, эмнэлгийн болон түргэн тусламжийн ажилтан, оффис менежер, зураг авалтын ажлын байрны аюулгүй байдал хариуцсан ажилтан болон ачигч, техникийн хэрэгсэл хариуцсан ажилтан, цагийн ажилчдын цалин хөлс, түүнтэй холбоотойгоор Монгол Улсад төлсөн холбогдох татвар;

10.Монгол дахь зураг авалтын явцад зарцуулсан кино багийн байр, хоол, унааны зардал;

11.Монгол Улсын нутаг дэвсгэр доторх зураг авалт хийх байршил судлах багийн ажилтан болон дамжин өнгөрөх жолооч нар зэрэг техникийн багийн байр, бусад түрээсийн зардал;

12.Монгол Улсын нутаг дэвсгэрт кино зураг авалттай холбоотой тээвэрлэлт (зураг авалтын байршил судлах, зөвшөөрөл авах ба дүр сонгох)-ийн зардал;

13.Зураг авалттай шууд холбоотой тавилга, машин механизм (майхан, нарны хаалт, зөөврийн ширээ, хашаа, генератор гэх мэт)-ын түрээсийн зардал;

14.Зураг авалтын зориулалтаар объект, байршил түрээслэх зардал;

15.Зураг авалтад зориулж амьтан, зэвсэг, түргэн тусламж, гал командын машин түрээслэхэд гарсан зардал;



16. Кино зураг авалттай холбоотой кино сет буюу кино зураг авах байгууламж барих зардал;

17. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа техник, тоног төхөөрөмж-камер, гэрэл, дуу болон цахилгаан, тусгай эффeктийн үйлчилгээний түрээсийн зардал;

18. Монголд байрлах бүх жүжигчид болон кино багийнхны байр, хоол, Монгол Улсын нутаг дэвсгэр доторх тээвэрлэлтийн зардал;

19. Монгол дахь кино багтай холбоотой даатгалын зардал;

20. Монгол дахь зураг авалтад гал сөнөөгч машин, гал сөнөөгч ажиллуулах, хамгаалалтын үйлчилгээ авах болон бусад байгууллагаас гэрээний дагуу ашиглах, түрээслэх бусад үйлчилгээний зардал;

21. Бусад кино зураг авалттай холбоотой үйлчилгээ, түрээсийн зардал.

---o0o---

Журмын 2 дугаар хавсралт

СОЁЛЫН ШАЛГУУР

№	Соёлын шалгуурыг илэрхийлэх үзүүлэлт	Оноо (0-30)
1.	Үйл явдал нь монголын түүх, домогт үндэслэсэн	0-3
2.	Монгол хүнийг эергээр харуулсан	0-2
3.	Монгол Улсыг төлөөлөх газар нутаг, хот, гудамж, барилга байгууламж болон бусад байршил, орчин	0-2
4.	Монголын утга зохиол, урлагийн бүтээлээс сэдэвлэсэн	0-2
5.	Монголын өнөөгийн нийгэм, улс төрийн асуудлыг хөндсөн, эсхүл түүхийн тодорхой үеийг онцолсон	0-2
6.	Монгол Улсын үнэт зүйл, соёлын үнэт зүйл, соёлын олон төрөл, тэдгээрийн нэг хэсгийг эергээр илэрхийлсэн, харуулсан	0-2
7.	Монголын ёс заншил, уламжлалыг онцлон харуулсан	0-2
8.	Кино бүтээх үйл явц Монголын кино урлагийн хөгжилд нөлөөлөхүйц хувь нэмэр оруулсан	0-2
9.	Кино бүтээж байгаа дараах голлох уран бүтээлчдийн аль нэг Монгол Улсын иргэн: 1. найруулагч; 2. продюсер; 3. кино зураглаач (DOP);	0-7 (уран бүтээлч тус бүрд 0.5 оноо)



	4. кино зохиолч; 5. гол дүрийн жүжигчин; 6. туслах жүжигчдийн 3 хүртэлх ; 7. хөгжмийн зохиолч (үндсэн); 8. кино үйлдвэрлэлийн зохион бүтээгч; 9. хувцасны загвар зохион бүтээгч; 10. редактор; 11. нүүр будалт, хувиргалтын уран бүтээлч; 12. дууны найруулагч; 13. продакшн менежер буюу зургийн дарга; 14. пост продакшн эсхүл график эффектийн удирдагч.	
10.	Киноны эцсийн хувилбарыг монгол хэлээр бэлтгэсэн, дуу оруулсан	0-2
11.	Энэ шалгуурын 9-д заасан уран бүтээлчдээс бусад уран бүтээлийн багийн гишүүдийн 50 буюу түүнээс дээш хувь Монгол Улсын иргэн бол	0-4

---оо---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 4 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 150

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Төрийн тусгай хамгаалалтын газрын туг, бэлгэ тэмдгийн загвар, хэрэглэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн тусгай хамгаалалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 1995 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 127 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ц.НЯМДОРЖ

Засгийн газрын 2022 оны 150 дугаар
тогтоолын хавсралт

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ГАЗРЫН ТУГ, БЭЛГЭ ТЭМДГИЙН ЗАГВАР, ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Төрийн тусгай хамгаалалтын газрын тугийг үйлдэх, залах, байрлуулах, хадгалах, хамгаалах, зөөвөрлөх болон Төрийн тусгай хамгаалалтын газрын бэлгэ тэмдгийг үйлдэх, байрлуулах, хэрэглэхэд энэ журмыг мөрдөнө.

Хоёр.Төрийн тусгай хамгаалалтын газрын тугийн тодорхойлолт, загвар

2.1.Туг нь нийт бие бүрэлдэхүүний золбоо хийморийн бэлгэдэл мөн.

2.2.Төрийн тусгай хамгаалалтын газрын туг (цаашид “туг” гэх) нь сүлд, далбаа, ишнээс бүрдэнэ:

2.2.1.Тугийн сүлд нь гилбэр, орой, залаа, бүчтэй байна. Гилбэрийг 25 см урттай гангаар хийнэ. Орой нь бад цэцгэн хөлтрөгтэй, зэвэрдэггүй төмөрлөгөөр бүрсэн 15 см голчтой дээвэр, 81 сүвэгч бүхий 2 см өргөн хүрээтэй монгол гэрийн хэлбэртэй байна. Залааг цагаан, шарга болон хар зүсмийн азарганы 25 см урттай хөхөл дэлээр 4 хар, 4 цагаан байхаар алаглуулж хийнэ. Дөрвөн бүч болон бүслүүрийг цагаан өнгийн савхиар хийж цэнхэрээр хүрээлэн 90 хэмийн өнцөгтэй хэл гарган хийж, залааны гадуур унжуулан хооронд нь холбож уулзвар дээр нь зэвэрдэггүй төмөрлөгөөр бүрсэн 2 см голчтой дөрвөн толийг бэхэлнэ. Гилбэр, оройг онгиор холбож, тугийн ишинд бэхэлнэ;

2.2.2.Далбааг 15х100 см-ийн харьцаатай улаан хүрэн өнгийн хамба хилэн даавуугаар хийж, давхарлаж оёно. Далбаа нь дээд, баруун, доод талаараа шар цацагтай, далбааг ишинд уях дөрвөн бүчтэй байна. Далбааны голд Төрийн тусгай хамгаалалтын газрын бэлгэ тэмдгийг байрлуулж, хоёр талаар нь “Төрийн тусгай хамгаалалтын алба” гэсэн үгийг уйгаржин монгол бичгээр бичиж, алтлаг шар өнгийн торгомсог эдээр оёно;

2.2.3.Тугийн ишинд хос цацраг бүхий алтан шар манжлага уягдана. Тугийн ишийг 3,5 см-ийн голчтой 250 см урт хус модоор хийж, улаан хүрэн өнгөөр будна.

2.3.Тугийн гэрийг 220х50 см-ийн харьцаатай улаан хүрэн өнгийн торгомсог эдээр оёж хийнэ. Гэрийг бөхлөхөд зориулсан, хавж тогтоосон бүчтэй байна. Тугийг аяны байдалд авч явахад зориулагдсан тусгай хайрцагтай байх ба хоргонд байрлуулахад ашиглах богино иштэй байж болно.



Гурав.Тугийг залах

3.1.Тугийг дараах тохиолдолд хүндэтгэлтэйгээр зална:

3.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд Төрийн тусгай хамгаалалтын газрын төв байранд ирэх үед;

3.1.2.Цэргийн ёслолын жагсаалд Төрийн тусгай хамгаалалтын бие бүрэлдэхүүн оролцох үед;

3.1.3.Төрийн тусгай хамгаалалтын газрын ойн баяр тэмдэглэх үед;

3.1.4.Төрийн тусгай хамгаалалтын газрын бие бүрэлдэхүүний жагсаалын нэгдсэн үзлэг хийх үед;

3.1.5.Төрийн тусгай хамгаалалтын газрын оны тэргүүний нэгж болон албан хаагчийг дэлгээ тугийн өмнө зургаа авахуулах үед;

3.1.6.Ёслол, хүндэтгэлийн ажиллагаанд тугийг залах шаардлагатай гэж үзэж байгууллагын даргын шийдвэр гарсан тохиолдолд.

3.2.Тугийг залах, хүндэтгэл, ёслолын арга хэмжээнд авч явахад Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын тушаалаар туг залагч, тугч, туг хамгаалагч, тугийн салааг томилно.

3.3.Туг хамгаалах тугийн салааны бүрэлдэхүүний тоог тухай бүрд шийдвэрлэнэ. Тугийн салааны алба хаагчдад галт зэвсэг олгох, хураан авах ажлыг байгууллагын даргын тушаалаар томилогдсон албан тушаалтан хариуцна.

3.4. Тугийг залж гаргах, жагсаалд байрлуулах, буцааж оруулахдаа Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмүүдийн “Цэргийн жагсаалын дүрэм”-ийн холбогдох заалтыг удирдлага болгоно.

3.5.Гамшгийн болон байршил солих үед тугийг Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын тушаалаар заасан газар, хугацаанд шилжүүлэн байрлуулна.

Дөрөв.Тугийг хадгалах, хамгаалах

4.1.Тугийг дараах байдлаар хадгална:

4.1.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын төв байранд тусгайлан тоногдсон тасалгаа (шилэн хорго)-нд хүндэтгэлтэйгээр залж байнга хадгална;



4.1.2.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын төв байрнаас өөр газарт түр байрлуулах тохиолдолд тухайн газарт тусгайлан бэлтгэсэн байранд байрлуулна.

4.2.Тугийг хадгалах, арчлах асуудлыг хариуцсан албан хаагчийг Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын тушаалаар томилж, хадгалах, арчлах асуудалд Төрийн тусгай хамгаалалтын газрын дэд дарга хяналт тавина.

4.3.Туганд улиралд 1 удаа үзлэг хийж, одон, гилбэр, орой, залаа, бүч, иш, гэрний бүрэн бүтэн байдлыг шалгаж, хадгалалт, хамгаалалттай холбоотой илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч, энэ тухай Төрийн тусгай хамгаалалтын газрын даргад илтгэх хуудсаар танилцуулна.

4.4.Энэ журмын 4.3-т заасан үзлэгийг хариуцсан алба хаагч, нууц хамгаалах ажилтныг байлцуулан хийж, үзлэг хийсэн он, сар, өдөр, илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах талаар авсан арга хэмжээний талаар үзлэгийн дэвтэрт тэмдэглэл үйлдэнэ.

4.5.Туг байрлуулах тасалгаа (шилэн хорго)-г дохиолол, камерын системээр тоноглох бөгөөд харуул хамгаалалтын асуудал хариуцсан нэгжийн хяналтад байна.

4.6.Туг норсон буюу чийг авсан тохиолдолд төв байрны гадна талд нар тусаагүй газарт, эсхүл байран дотор хатаана. Энэ тохиолдолд туг хамгаалагчаар хамгаалуулна.

4.7.Тугийг төв байрнаас өөр газарт залах, түр байрлуулах тохиолдолд зориулалтын гэрэнд хийж, туг зөөвөрлөх тээврийн хэрэгсэл гаргана.

4.8.Туг залах, зөөвөрлөх, буцаан байрлуулах үед дэд дарга буюу түүний томилсон алба хаагч, тугийг хадгалах, арчлах асуудлыг хариуцсан алба хаагчийн хамт үзлэг хийж хүлээлцэнэ.

Тав.Туг хүлээлгэн өгөх, шинээр оёх, засварлах

5.1.Гэмтэл ихтэй буюу удаан хугацаагаар хадгалснаас хэврэгшин сэмэрч гэмтсэн, засаж сэлбэх бололцоогүй болсон тугийг солино.

5.2.Тугийг шинээр оёх буюу засварлах шийдвэр гаргахдаа Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын тушаалаар томилогдсон комисс, тугийг хадгалах, арчлах асуудлыг хариуцсан албан хаагчийг байлцуулан туганд үзлэг хийнэ. Комисс нь тугийн гэмтэл, түүний үүссэн шалтгаан нөхцөл, шинээр оёх буюу засварлах тухай дүгнэлт гаргана.

5.3.Тугийг шинээр оёх буюу засварлах тухай шийдвэрийг Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга гаргана.



5.4.Шийдвэрийг үндэслэн байгууллагын хангалтын асуудал хариуцсан нэгж тугийг засварлах буюу шинээр оёх ажлыг хариуцан гүйцэтгэнэ. Тугийг засварт өгөх, хүлээн авахдаа үзлэгийн дэвтэрт тэмдэглэл хөтөлнө.

5.5.Хуучин тугийг товч түүхийн хамт байгууллагын архивын асуудал хариуцсан нэгжид шилжүүлнэ.

5.6.Туганд толбо, үрчлээ үүсэж бохирдсон тохиолдолд цэвэрлэх ажлыг тугийг хадгалах, арчлах асуудлыг хариуцсан алба хаагч хариуцан гүйцэтгэж, дүнг үзлэгийн дэвтэрт тэмдэглэн Төрийн тусгай хамгаалалтын газрын дэд даргад илтгэнэ.

Зургаа.Төрийн тусгай хамгаалалтын газрын бэлгэ тэмдгийн тодорхойлолт, загвар

6.1.Төрийн тусгай хамгаалалтын газрын бэлгэ тэмдэг (цаашид “бэлгэ тэмдэг” гэх) нь түүний сүр хүч, цог хийморийн илэрхийлэл мөн.

6.2.Бэлгэ тэмдэг нь бүхэлдээ алтан шар өнгөтэй байх бөгөөд түүний төв дунд төр, улсаа дээдлэн хүндэтгэхийн бэлгэдэл Төрийн их цагаан тугийг монгол үндэстний эрхэмлэдэг хадган цэнхэр дэвсгэр дээр дүрсэлсэн байна. Төрийн их цагаан тугийн гурван талд төр, засгийн дээд байгууллага, хамгаалуулагчийн аюулгүй байдлыг сахин хамгаалах утгыг илэрхийлж хүчит их гурван алтан сум, бамбай дүрсэлж “ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТ” гэсэн үгийг товойлгон бичнэ. Эртний монголчуудын сүр сүлд их цагаан туг, хүчит их алтан сум, бамбай нь эзэн Чингисийн өмөг түшиг хишигтэн цэргийн уламжлалыг хадгалсан түүхэн утга агуулгыг давхар илэрхийлнэ. Бэлгэ тэмдгийг тойруулан ашид мөнх мандан бадрахын өлзийт бэлгэдэл дөрвөн зүг, найман зовхист цацрах нарыг дүрслэнэ.

Долоо.Бэлгэ тэмдгийг үйлдэх, хэрэглэх

7.1.Бэлгэ тэмдгийг загварын дагуу гоёмсог, үзэмжтэй үйлдэж, Төрийн тусгай хамгаалалтын газрын төв байранд, гаднаас орж ирэхэд нүдэнд харагдахуйц газар байнга байрлуулна.

7.2.Бэлгэ тэмдгийг загварын дагуу үйлдэж Төрийн тусгай хамгаалалтын газрын албан тасалгаанд байрлуулж болно.

7.3.Төрийн тусгай хамгаалалтын газрын алба хаагч даавуун дээр утсаар өнгө ялган үйлдсэн бэлгэ тэмдгийг дүрэмт хувцасны зүүн ханцуйны дээд хэсэгт хадаж хэрэглэнэ.

7.4.Бэлгэ тэмдгийг тус байгууллагын хаяг, хэвлэмэл хуудас, албаны бусад баримт бичиг, эд зүйл, алба хаагчийн үнэмлэх, нэрийн хуудас, хамгаалалтын болон тусгай зориулалтын автотээврийн хэрэгсэл, бэлэг дурсгалын зүйл дээр дүрслэн хэрэглэж болно.

Найм.Бусад зүйл

8.1.Энэ журмын холбогдох заалтыг зөрчсөн тохиолдолд Төрийн албаны тухай хууль, Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---о0о---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 4 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 153

Улаанбаатар
хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 156.6-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссын дүрэм”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам, дүрэм батлах, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 1999 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 122 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

А.АРИУНЗАЯА

Засгийн газрын 2022 оны 153
дугаар тогтоолын хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН ЭРХИЙН МАРГААН ТАСЛАХ КОМИССЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү дүрмийн зорилго нь Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.16-д заасан хөдөлмөрийн эрхийн маргааныг урьдчилан шийдвэрлэх чиг үүрэг бүхий хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссыг байгуулах, уг комиссоор хөдөлмөрийн эрхийн маргааныг урьдчилан шийдвэрлэхтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах орон тооны бус байнгын ажиллагаатай комиссыг Хөдөлмөрийн тухай хуулийн 156.1-д заасан 20 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад байгуулна.

1.3. Хөдөлмөрийн эрхийн маргаан (цаашид “маргаан” гэх)-ыг шийдвэрлэхээр 20-оос доош ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага байнгын бус комисс байгуулж болно.

1.4. Энэ дүрмийн 1.2, 1.3-т заасан орон тооны бус байнгын ажиллагаатай комисс, байнгын бус комисс үйл ажиллагаагаа хөдөлмөрийн хууль тогтоомж болон энэхүү дүрмийг баримтлан явуулна.

Хоёр. Комиссын бүрэлдэхүүн, төлөөлөгчийг сонгох, томилох

2.1. Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс (цаашид “комисс” гэх) нь ажил олгогч болон аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрчний эвлэл, хэрэв ийм байгууллага байхгүй бол нийт ажилтны хурлаас сонгогдсон ажилтны тэнцүү тооны төлөөллөөс бүрдэх бөгөөд 4 ба түүнээс дээш тооны бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаагаар байгуулагдана. Комиссын бүрэлдэхүүний тоог ажил олгогч тогтооно.

2.2. Энэ дүрмийн 1.2-т заасан комиссын бүрэн эрхийн хугацаа дуусахаас 1 сараас доошгүй хугацааны өмнө энэхүү дүрмийн дагуу дараагийн комиссыг шинээр байгуулах бөгөөд өмнөх комиссын бүрэн эрхийн хугацаа дууссан өдрөөс шинээр байгуулагдсан комисс бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлнэ.

2.3. Аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрчний эвлэл нь комиссын бүрэлдэхүүнд орох үйлдвэрчний эвлэлийн төлөөлөгчийг тухайн үйлдвэрчний эвлэлийн бүх гишүүдийн буюу түүнтэй адилтгах хурлаар хэлэлцэн сонгож, хурлын шийдвэрээ баталгаажуулан ажил олгогч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

2.4. Аж ахуйн нэгж, байгууллагад хэд хэдэн үйлдвэрчний эвлэл байгаа тохиолдолд комиссын бүрэлдэхүүнд орох үйлдвэрчний эвлэлийн төлөөлөгчдийн тоог гишүүдийнхээ тооны харьцааг үндэслэн тогтоож, энэ дүрмийн 2.3-т заасны дагуу ажил олгогч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

2.5. Аж ахуйн нэгж, байгууллага нь үйлдвэрчний эвлэлгүй, эсхүл үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн тоо нь тухайн байгууллагын нийт ажилтны 30 хувьд хүрэхгүй бол комиссын бүрэлдэхүүнд орох ажилтны төлөөлөгчийг сонгохдоо нийт ажилтны хурлыг зохион байгуулж, нууц санал хураалт явуулж олонхын саналаар сонгоно. Комиссын бүрэлдэхүүнд орохыг хүссэн ажилтан нэрээ дэвшүүлэх эрхтэй.

2.6. Ажил олгогч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд нь энэ дүрмийн 2.5-д заасан нийт ажилтны хурлыг ажилтныг биечлэн,

эсхүл цахимаар оролцуулах зэрэг боломжит хэлбэрийг ашиглан зохион байгуулна. Хурлыг нийт ажилтны 50 ба түүнээс дээш хувь оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцно.

2.7.Комиссын бүрэлдэхүүнд орох ажил олгогчийн төлөөлөгчийг ажил олгогч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдийн шийдвэрээр томилно.

2.8.Ажил олгогч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд энэ дүрмийн 2.3, 2.4, 2.5, 2.7-д заасныг үндэслэн комисс байгуулсан тухай шийдвэр гаргана.

2.9.Комиссын бүрэлдэхүүнд энэ дүрэмд заасны дагуу өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тохиолдолд ажил олгогч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд тухай бүрд шийдвэр гаргана.

2.10.Ажил олгогч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд нь комисс байгуулагдсан, комиссын бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон талаарх мэдээллийг аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухай бүр мэдээлнэ.

2.11.Комиссын гишүүнийг сонгосон, эсхүл томилсон тал дараах тохиолдолд ажил олгогч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдэд мэдэгдэж, комиссын гишүүнээс хугацаанаас нь өмнө чөлөөлүүлнэ:

2.11.1.Хөдөлмөрийн тухай хуулийн 78, 79, 80 дугаар зүйлд заасан нөхцөл байдал үүссэн;

2.11.2.энэ дүрмийн 4.2-т заасан зарчим, ёс зүйн шаардлагыг 2 ба түүнээс дээш удаа зөрчсөн;

2.11.3.комиссын гишүүн чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан.

2.12.Хугацаанаас өмнө чөлөөлөгдсөн гишүүний оронд өөр гишүүнийг энэхүү дүрэмд заасны дагуу 3 жилийн хугацаагаар сонгож, томилно.

2.13.Комиссын анхны хуралдааныг насаар хамгийн ахмад төлөөлөгч даргална. Тус хуралдаанаас комиссын дарга болон нарийн бичгийн даргыг гишүүд зөвшилцөж сонгоно. Комиссын дарга болон нарийн бичгийн даргын үүргийг нэг талын төлөөлөгчид нэгэн зэрэг гүйцэтгэж болохгүй.

Гурав.Комисс гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх

3.1.Комисс нь маргалдагч талаас гаргасан хөдөлмөрийн эрхийн маргааныг урьдчилан шийдвэрлэнэ.

3.2.Маргалдагч тал хөдөлмөрийн эрхийн маргаан бүхий гомдлоо Хөдөлмөрийн тухай хуулийн 154.2-т заасан хугацаанд комисст хандан цаасан болон цахим хэлбэрээр гаргана. Гомдол гаргах хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол маргалдагч талын хүсэлтээр уг хугацааг сэргээх асуудлыг шүүх шийдвэрлэнэ. Гомдлыг холбогдох ууль тогтоомжид заасны дагуу маргалдагч талын төлөөлөгч гаргаж болно.

3.3.Комиссын нарийн бичгийн дарга энэ дүрмийн 3.2-т заасан гомдлыг хүлээн авч ажлын 1 өдөрт багтаан бүртгэх бөгөөд хувийг маргалдагч талуудад ажлын 1 өдрийн дотор хүргүүлнэ.

3.4.Нарийн бичгийн дарга гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 3 өдөрт багтаан комиссын хуралдаан (цаашид “хуралдаан” гэх)-ыг зохион байгуулахаар товлож, хуралдааны товын талаарх мэдээллийг комиссын гишүүд болон маргалдагч талуудад нэн даруй мэдэгдэнэ. Хуралдааныг ажлын цагаар хуралдуулахаар товлон.

3.5.Хуралдаанд нийт гишүүдийн дийлэнх олонх оролцсон тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно.

3.6.Комисс гомдлыг маргалдагч талуудыг оролцуулан шийдвэрлэнэ. Маргалдагч тал болон комиссын аль нэг гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралдаанд цахим хэлбэрээр оролцохоор бол ажлын 1-ээс доошгүй өдрийн өмнө нарийн бичгийн даргад энэ талаар мэдэгдэнэ.

3.7.Хуралдаанд гомдол гаргагч хүндэтгэн үзэх шалтгаанаар ирээгүй боловч гаргасан гомдолтой холбоотойгоор маргалдагч нөгөө талтайгаа тохиролцож болох нөхцөлийг тодорхой тусгасан саналыг хуралдаан эхлэхээс өмнө комисст бичгээр ирүүлсэн бол хуралдаанд оролцсонд тооцно.

3.8.Хуралдааныг комиссын дарга удирдах бөгөөд түүний эзгүйд комиссын дарга сонгогдсон талаас хуралдаан удирдагчийг сонгоно. Комиссын дарга гомдлын талаар дэлгэрэнгүй танилцуулж, комиссын гишүүд маргалдагч талуудаас маргааны талаар асууж тодруулна.

3.9.Комиссын нарийн бичгийн дарга хуралдааны тэмдэглэлийг энэ дүрмийн хавсралт дахь загварын дагуу хөтөлнө.

3.10.Хөдөлмөрийн тухай хуулийн 154.4-т заасны дагуу комисс хөдөлмөрийн эрхийн маргаан урьдчилан шийдвэрлэх явцад талууд маргаантай асуудлаар харилцан тохиролцсон бол энэ тухай тэмдэглэл үйлдэж маргалдагч талууд гарын үсэг зурснаар маргаан шийдвэрлэгдсэнд тооцно.

3.11.Хуралдаанд маргалдагч талууд өөрсдийн саналыг тайлбарлах эрхтэй байна. Комиссын гишүүд маргааны агуулгыг талуудад ойлгуулах, аль болох харилцан тохиролцож шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх хэлбэрээр маргааныг урьдчилан шийдвэрлэх арга хэмжээнд оролцоно.



3.12.Хуралдаанаар гомдол гаргагчийн шаардлагын зарим хэсгийг маргалдагч нөгөө тал хүлээн зөвшөөрсөн ч гомдол гаргагч гомдолтой гэж үзсэн хэвээр байгаа бол энэ тухай хуралдааны тэмдэглэлд тусгуулж, маргалдагч талууд болон тухайн хуралдаанд оролцсон комиссын гишүүд гарын үсэг зурснаар маргааныг урьдчилан шийдвэрлэх арга хэмжээ дуусгавар болно.

3.13.Хуралдаанд гомдол гаргагч хүндэтгэн үзэх шалтгаанаар ирээгүй бөгөөд түүний энэ дүрмийн 3.7-д заасны дагуу гаргасан саналыг маргалдагч нөгөө тал бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь хүлээн зөвшөөрсөн бол хуралдааны тэмдэглэлд энэ тухай тодорхой тусгаж, маргалдагч нөгөө тал болон тухайн хуралдаанд оролцсон комиссын гишүүд гарын үсэг зурна. Комиссын нарийн бичгийн дарга хуралдааны тэмдэглэлийг гомдол гаргагчид хуралдаан болсноос хойш ажлын 2 өдрийн дотор танилцуулах бөгөөд гомдол гаргагч тэмдэглэлтэй танилцаж, хэрэв гомдолтой гэж үзсэн хэвээр байгаа бол энэ тухай хуралдааны тэмдэглэлд нэмж тусгуулан гарын үсэг зурснаар маргааныг урьдчилан шийдвэрлэх арга хэмжээ дуусгавар болно.

3.14.Гомдол гаргагч хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаанаар ирээгүй бөгөөд гаргасан гомдолтой холбоотойгоор маргалдагч нөгөө талтайгаа тохиролцож болох нөхцөлийг тодорхой тусгасан саналыг энэ дүрмийн 3.7-д заасны дагуу комисст ирүүлээгүй, эсхүл хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол гомдлыг хэрэгсэхгүй болгож хуралдааныг дуусгасан тухай тэмдэглэл үйлдэж комиссын гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

3.15.Комиссоор урьдчилан шийдвэрлэсэн тэмдэглэлийг хүлээн авснаас хойш маргалдагч аль нэг тал ажлын таван өдөрт багтаан холбогдох хууль тогтоомжид заасны дагуу баталгаажуулахаар шүүхэд хүсэлт гаргаж болно.

3.16.Комисс маргааныг урьдчилан шийдвэрлэх журмаар зохицуулж чадаагүй бол комиссын тэмдэглэлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор маргалдагч аль нэг тал маргааныг урьдчилан шийдвэрлүүлэхээр сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороонд хандах эрхтэй.

3.17.Энэ дүрмийн 3.10-т заасан шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхэд хандах эрхтэй.

Дөрөв.Комиссын эрх, үүрэг, гишүүний ёс зүй

4.1.Комисс нь дараах эрх, үүрэгтэй байна:

4.1.1.шаардлагатай гэж үзвэл маргалдагч талуудаас маргаантай холбоотой асуудлаар мэдээлэл, тайлбарыг гаргуулан авах;

4.1.2.маргааныг урьдчилан шийдвэрлэх явцад олж мэдсэн хувь хүний болон байгууллагын нууцыг хадгалах, задруулахгүй байх;



4.1.3.комиссын үйл ажиллагааны тайлан (ирүүлсэн гомдлын тоо, төрөл, хуралдааны тоо, шийдвэрлэгдсэн байдлын талаар)-г ажил олгогч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд болон нийт ажилтанд жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор мэдээлэх.

4.2.Комиссын гишүүн нь Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаас гадна дараах зарчим, ёс зүйн шаардлагыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно:

4.2.1.хараат бусаар чиг үүргээ хэрэгжүүлэх;

4.2.2.хуралдааны ирц, оролцоог хангах, комиссын гишүүний хувьд даалгасан ажил үүргийг биелүүлж, энэ дүрмийг хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гаргах;

4.2.3.комиссын гишүүний үүргээс гадна ажилтны хувьд хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргахгүй байх.

Тав.Талуудын эрх, үүрэг

5.1.Маргалдагч талууд нь хөдөлмөрийн эрхийн маргааныг урьдчилан шийдвэрлэх явцад дараах эрх, үүрэгтэй байна:

5.1.1.гомдол гаргагч тал нь маргааныг аль болох харилцан тохиролцож шийдвэрлэхээр маргалдагч нөгөө талаас гаргаж буй идэвх, санаачилгыг хүндэтгэх;

5.1.2.маргалдагч нөгөө талаа хохироох зорилгоор хөдөлмөрийн эрхийн маргааны агуулгыг зориуд өөрчилж, өөрт ашигтай байдал руу чиглүүлэхгүй байх;

5.1.3.маргаан урьдчилан шийдвэрлүүлэх явцад өөрийн нууц, эмзэг гэж үздэг асуудал хөндөгдөж болзошгүй гэж үзвэл комиссын дарга, эсхүл нарийн бичгийн даргад урьдчилан, эсхүл тухайн үед нь мэдэгдэж, нууцыг нь хадгалах, хамгаалахыг комиссын гишүүд болон маргалдагч нөгөө талаас шаардах;

5.1.4.маргааныг урьдчилан шийдвэрлэх явцад олж мэдсэн хувь хүний болон байгууллагын нууцыг хадгалах, задруулахгүй байх.

5.2.Ажил олгогч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд нь дараах эрх, үүрэгтэй байна:

5.2.1.комиссыг хэвийн ажиллах нөхцөлөөр хангах;

5.2.2.маргааныг аль болох харилцан тохиролцож шийдвэрлэх хүсэл эрмэлзэлтэй байх, гомдол гаргасан ажилтны хууль ёсны эрх, ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд хүндэтгэлтэй хандах;



5.2.3.комиссын гишүүний хуралдаанд оролцсон хугацааг ажилласан цагт тооцох;

5.2.4.маргааныг урьдчилан шийдвэрлэх явцад олж мэдсэн хувь хүний болон байгууллагын нууцыг хадгалах, задруулахгүй байх;

5.2.5.комиссын бүрэлдэхүүнд орох үйлдвэрчний эвлэлийн, эсхүл ажилтны төлөөлөгчийг сонгоход хөндлөнгөөс нөлөөлөхгүй байх;

5.2.6.ажилтнуудыг комиссоос ирүүлсэн энэ дүрмийн 4.1.3-т заасан тайлантай танилцах боломжоор хангах, тайланг байгууллагын цахим хуудаст байршуулах;

5.2.7.комиссоор урьдчилан шийдвэрлэсэн хөдөлмөрийн эрхийн маргааны тоо, шийдвэрийн биелэлтийн талаарх тайлан мэдээг аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдөрт багтаан хүргүүлэх.

---о0о---

Дүрмийн хавсралт

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН НЭР

Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссын хуралдааны тэмдэглэл

Огноо ... хот/ аймаг

Дугаар

I. Комиссын хуралдаанд оролцсон

Ажилтны овог, нэр: Ажил олгогч, эсхүл түүнийг төлөөлөх эрхий бүхий этгээдийн овог нэр, албан тушаал:

II. Комиссын бүрэлдэхүүн:

Үйлдвэрчний эвлэл/Ажилтныг төлөөлөх гишүүн:	Ажил олгогчийг төлөөлөх гишүүн:
1.	1.
2.	2.

III. Гомдол гаргагчаас гаргасан гомдол, түүний шаардлага



IV. Хэлэлцсэн асуудал:

Талууд харилцан тохиролцсон, тохиролцоогүй болон гомдол гаргагч гомдлоо буцааснаар маргааныг урьдчилан шийдвэрлэх арга хэмжээ дуусгавар болсны аль нь болох:

- Талууд харилцан тохиролцсон бол V-д харилцан тохиролцоог товч, тодорхой дурдах
- Талууд тохиролцоогүй бол VI дахь хэсэгт тохиролцоогүй гэж тэмдэглэж, маргааныг урьдчилан шийдвэрлэх арга хэмжээ дуусгавар болно.
- Гомдол гаргагч гомдлоо буцааснаар маргааныг урьдчилан шийдвэрлэх арга хэмжээг дуусгавар болно:

V. Хуралдааны явцад маргааныг ажилтан ба ажил олгогч хоорондоо харилцан тохирч шийдвэрлэсэн нь:

VI. Талууд харилцан тохиролцоогүй

Талууд маргааныг урьдчилан шийдвэрлэх журмаар харилцан тохиролцоогүй тул арга хэмжээг дуусгавар болгов. Иймд энэхүү тэмдэглэлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор маргалдагч аль нэг тал маргааныг урьдчилан шийдвэрлүүлэхээр ажил олгогчийн харьяалах сум, дүүргийн хөдөлмөрийн маргаан зохицуулах гурван талт хороонд хандах эрхтэй.

VII. Тэмдэглэлтэй танилцан зөвшөөрсөн:

Хуралдаан удирдагч:

Хуралдааны нарийн бичгийн дарга:

Хуралдаанд оролцсон комиссын гишүүд:

Гомдол гаргасан:

Маргалдагч нөгөө тал:

---o0o---



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 4 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 154

Улаанбаатар
хот

Жагсаалт батлах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 6.1.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсад 2022 онд зохион байгуулах олон улс, тивийн аварга шалгаруулах тэмцээний жагсаалт”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолын хавсралтад заасан тэмцээний зохион байгуулалтын зардалд шаардагдах санхүүгийн дэмжлэгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу 2022 оны батлагдсан төсвөөс гаргахыг Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Ц.Шаравжамцад даалгасугай.

3.Монгол Улсад зохион байгуулагдах олон улс, тивийн аварга шалгаруулах тэмцээний бэлтгэл ажлыг сайтар ханган зохион байгуулж, дүнг танилцуулахыг Биеийн тамир, спортын улсын хороо (Ц.Шаравжамц)-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ц.НЯМДОРЖ

Засгийн газрын 2022 оны 154
дүгээр тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСАД 2022 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ ОЛОН УЛС, ТИВИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ЖАГСААЛТ

No	Тэмцээний нэр
1.	Ази тивийн аварга шалгаруулах Чөлөөт бөхийн насанд хүрэгчдийн тэмцээн
2.	Жүдо бөхийн “Улаанбаатар их дуулга-2022” олон улсын тэмцээн
3.	Ази тивийн аварга шалгаруулах Таеквондогийн өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн тэмцээн
4.	Ази тивийн аварга шалгаруулах Пауэрлифтингийн насанд хүрэгчдийн тэмцээн
5.	Жюү жицүгийн “Улаанбаатар Про” олон улсын тэмцээн

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2,25

Индекс: 200003